



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/121

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2023 оны "Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" А/370 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний хүрээнд голомтод ажилласан ажилчдын хөлс, шатахуун, хоол хүнс, халдвар хамгааллын хувцас хэрэгсэлд нийт 5,130,700 (таван сая нэг зуун гучин мянга долоон зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Орон нутаг хөгжүүлэх сангийн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ